



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/20

Мөрөн сум

Аймгийн аварга малчин тэргүүний ажилтан
иргэн, аж ахуй нэгжийг шалгаруулан шагнах тухай

Монгол Улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоол, 2016 оны 202 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны ээлжит IX хуралдааны 04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргээ тогтвортой өсгөн үржүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлэн амжилт гаргасан малчдыг аймгийн хошой аварга малчин, аймгийн аварга малчин, аймгийн аварга саальчин, аймгийн залуу аварга малчин гэр бүл, аймгийн хөдөө аж ахуйн аварга мэргэжилтэн, үр тариа, төмс хүнсний ногоо тарьж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аймгийн аварга тариаланч хамт олон, тариаланч, ногоочин, аймгийн тэргүүний үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийг тус тус шалгаруулан нэгдүгээр хавсралтаар, шагнал урамшуулалд зарцуулах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар, шагнал хүргэх ажлын багийн бүрэлдэхүүн, хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн аварга малчдын гэр бүлийг алдаршуулж аймгийн “Тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнаж, 2018 онд мянган мал тоолуулсан малчдад батламж олгосугай.

3. Шагнал урамшуулалд зарцуулах 45000000 төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас зарцуулахыг аймгийн ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

4. Шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч (З.Отгонбаяр) нарт даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай

ДАРГА



Л.ГАНБОЛД